Төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 4,037,896.5 мянган, туслах үйл ажиллагааны орлогыг 6,500.0 мянган, нийт орлогыг 4,044,396.5 мянган төгрөгөөр баталж, төсвийн тодотголоор 369,672.4 мянган төгрөгөөр нэмж, санхүүжилтийн эх үүсвэрийг 4,407,568.9 мянган, туслах үйл ажиллагааны орлогыг 6,500.0 мянга нийт зардлыг 4,414,068.9 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 4,414,068.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр улсын

төсвөөс 4,342,568.9 мянган төгрөгийн санхүүжилт авч туслах үйл ажиллагааны орлогоос 8,057.8 мянган төгрөг нийт 4,350,626.7 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, гүйцэтгэлээр 4,270,374.7 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 80,251.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,270,375.3 мянган төгрөг буюу 96.7.0 хувьтай байгаа нь цалин болон нэмэгдэл урамшуулал 41,738.4 мянган төгрөгөөр, мэдээлэл технологийн үйлчилгээ 6,202.4 мянган төгрөгөөр, тээвэр шатахуун 2,450.6 мянган төгрөгөөр, шуудан холбоо 1,708.1 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 4,706.3 мянган төгрөгөөр, бага үнэтэй түргэн элэгдэх зардал 1,132.0 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж 37,889.6 мянган төгрөгөөр, урсгал засвар 0.4 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 50,000.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

№	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71808	Боловсрол, шинжлэх ухааны бодлого, удирдлага	4,414,068.9	4,270,375.3	143,693.6	96.7
1.1	801010	Үндсэн үйл ажиллагааны зардал	3,756,382.8	3,702,320.8	54,062.0	99.0
1.2	801020	Туслах үйл ажиллагааны зардал	142,917.8	141,175.9	1,741.9	99.0
1.3	802260	Байр ашиглалтын үйлчилгээ	371,439.4	371,439.4	-	100.0
1.4	808020	Ажил олгогчоос олгох тэтгэмж	143,328.9	55,439.2	87,889.7	39.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Засгийн газрын нөөц сангаас 512,260.2 мянган төгрөг, НҮБ-н хүүхдийн сангаас 971,483.9 мянган төгрөг, Соёлын сайдын хөтөлбөр арга хэмжээнээс 403,000.0 мянган төгрөг, автомашины даатгалын орлого 135.9 мянган төгрөг нийт 1,886,880.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 1,350,566.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардалд 512,260.2 мянган төгрөг нийт 1,862,826.9 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 24,053.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж авлагаар бүртгэсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус яам нь боловсрол, шинжлэх ухааны салбарын бодлого зохицуулах, хэрэгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Тайлант онд тус байгууллагын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 96.0 хувьтай байна. Хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж

зарцуулсан төсвийн гүйцэтгэл 96.0 хувийн биелэлттэй, 0.4 хувиар зөрүүтэй буюу төсвийг хэмнэлттэй зарцуулж байгууллагын хүрэх үр дүнд хүрч ажилласан байна.

3.8 Аудитын гол асуудал

Засгийн газрын “Ой тэмдэглэн өнгөрүүлэх тухай” 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 250 дугаар тогтоолоор Монгол улсад орчин цагийн боловсролын салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойн арга хэмжээг дараах байдлаар зохион байгуулсан байна.

БШУС-ын 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/125 дугаар тушаал, 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/246 дугаар тушаалаар нийт 19 ажил зохион байгуулахаар төлөвлөсөн.

Соёлын сайдын хөтөлбөр арга хэмжээний зардлаас 403,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авч дараах ном, бүтээлүүдийг хэвлүүлэхэд зарцуулсан байна.

Үүнд “Britannica Боловсролын нэвтэрхий толь”, “Монголчуудын судар ном, бичиг соёлын өв-3” катологи, илтгэлийн эмхэтгэл, “Судар бичгийн хүрээлэн-100 жил, 100 үйл явдал” он дарааллын тэмдэглэл, Шинжлэх ухаан, технологийн салбарын эрх зүйн эмхэтгэл, Монголын археологийн хэвлэлийн хуудаснаа-1,2 боть, “Алс газар сурахаар одогсод” намтар түүх, Мал аж ахуй эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдмийн бүтээл-38 эмхэтгэл зэрэг ном, бүтээл хэвлүүлэхэд 192,400.0 мянган төгрөг, Монголч эрдэмтдийн их хурлуудын тухай түүхэн цуврал нэвтрүүлэгт 29,000.0 мянган төгрөг, судар ном, соёлын өвийн үзэсгэлэн зохион байгуулах, эрдэм шинжилгээний хуралд 128,600.0 мянган төгрөг нийт 350,000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад бүрэн мэдээлсэн байна.

БШУЯ нь 2021 онд нийт 11,060,581.9 мянган төгрөгийн 228 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 11,060,581.9 мянган төгрөгийн мэдээллийг ил тод байршуулжээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 1,994,529.1 мянган төгрөгийн 13 алдаа зөрчил илрүүлснийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад залруулга хийсэн байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 төлбөрийн актын биелэлт 100 хувь, 3 албан шаардлагын биелэлт 86.6 хувь, 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт-4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	3,600.0	1	3,600.0			100.0
Албан шаардлага	3	82,300.0	3	82,300.0	-	-	86.6
Зөвлөмж	2	8,300.0	2	8,300.0			100.0
Нийт дүн	6	94,200.0	6	94,200.0			95.5

Кассын тайлан бэлтгэх, төсвийг зориулалтын дагуу зарцуулах, зардлын утгыг барааны үнэ гэсэн ерөнхий нэрээр гүйлгээ хийхийг таслан зогсоож, төсвийг үр ашигтай хэмнэлттэй төлөвлөн зарцуулах гэсэн албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нэгдсэн үндэстний байгууллагын Хүн амын сан, Хүүхдийн сан, Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын хамтран хэрэгжүүлж байгаа “Сургалтын цахим контент удирдлагын системийг боловсруулах үйл ажиллагаа”-ны сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн төвшинд ашиглагдах цахим контент удирдлагын систем боловсруулах ажлын үйл ажиллагааны зохион байгуулалт, явц, хэрэгжилт, үр дүн, төсвийн зарцуулалт, тайлагналыг дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,040,370.1 мянган төгрөгийн 17 алдаа зөрчил илэрснээс, 1,994,529.1 мянган төгрөгийн 13 алдааг залруулж, 13,509.0 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 14,107.0 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 18,225.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Авлага дансанд бүртгэлтэй 28,500.0 мянган төгрөгийг шууд зардалд хааж дансны бичилт буруу хийсэн;

- Урьдчилгаа дансанд бүртгэлтэй 24,450.0 мянган төгрөгийг шууд зардалд хааж дансны бичилт буруу хийсэн;
- Харилцах данснаас 606,832.2 мянган төгрөгийн ажил гүйлгээг тооцоо үүсгээгүй шууд зардлын данс руу хааж бичсэн;
- Хагас жилийн санхүүгийн тайланд НДШ-н 18,300.0 мянган төгрөгийн өр төлбөрийг тусгаагүй;
- Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 24 нэр төрлийн 70,299.4 мянган төгрөгийн бараа материалыг данс бүртгэлд бүртгээгүй;

- "Судар бичгийн хүрээлэн-100" буюу орчин цагийн шинжлэх ухааны байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойн цогц арга хэмжээнд тусгагдсан "Шинжлэх ухаан технологийн салбарын эрх зүйн эмхэтгэл" гэсэн 20,000.0 мянган төгрөгийн 1000 номыг бүртгээгүй;
- Бараа материалын дансанд 12,300.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бүртгэсэн;
- Жолоочийн зам явах тооцооны хуудасгүй, 12,897.8 мянган төгрөгийн шатахуун зарцуулалтын тооцоо бодоогүй, тайлан гаргаагүй;
- Бараа материалын тайланг нэр төрөл тус бүрээр нь гаргаагүй 41,355.1 мянган төгрөгийн бараа материалыг хольж бүртгэсэн ;
- Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 1,012,214.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг холбогдох байгууллагад хүргүүлж шийдвэр гаргуулаагүй;
- Үндсэн хөрөнгөнд 1,020.0 мянган төгрөгийн бараа материалын шинж чанартай хөрөнгийг бүртгэсэн;
- Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 4 нэр төрлийн 20,959.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд бүртгээгүй;
- Шинжлэх ухаан, технологийн салбар, инновацын үйл ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмж гэж үзэж худалдан авсан 125,400.0 мянган төгрөгийн үнэ бүхий 19 ширхэг I Pad үндсэн хөрөнгөнд бүртгээгүй байна.

4.2 Төлбөрийн акт

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт

Батлагдсан нормоос илүү шатахуун зарцуулдаг автомашин албан хэрэгцээнд ашиглаж 1,300.0 мянган төгрөгийг зарцуулсан;

Томилолтын хуудас, гүйцэтгэсэн ажлын тайлан, удирдамж зэрэг анхан шатны баримтгүй 6,809.0 мянган төгрөгийн томиллолын зардлыг олгосон;

Хувь хүнтэй зөвлөн туслах ажлын гэрээ байгуулан гүйцэтгэсэн ажлын тайлан, гэрээ дүгнэсэн актгүйгээр 5,400.0 мянган төгрөгийг олгосон;

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай", Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолоор баталсан "Суудлын авто машины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" 8 дахь заалт "Төсвөөс санхүүждэг байгууллага хот дотор ажил, үйлчилгээнд хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж 2500смсм3-ээс дээш туулах чадвар өндөртэй, шатахуун их зарцуулдаг автомашин хэрэглэх, бүх шатны байгууллага, албан тушаалтан эрхлэх асуудлын хүрээний болон харьяа байгууллагаас автомашин гаргуулан хэрэглэх, шатахууны зардлыг төлүүлэхийг тус тус хориглосугай" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

4.3 Албан шаардлага

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт

Батлагдсан төсвөөс баяр ёслолын арга хэмжээнд зориулалт бусаар 2,207.0 мянган төгрөгийг зарцуулсан.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг хэмнэлттэй, зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар албан шаардлага өгөх.

2. Анхан шатны баримттай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт

Кассын 11,900,000.0 төгрөгийн тайлан гаргаагүй, анхан шатны баримтын гарын үсгийн бүрдэл дутуу, бэлэн мөнгөний зарцуулсан баримтыг үдэж архивын нэгж үүсгээгүй

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Сангийн сайдын 2000 онд баталсан Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 10-д "Өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого, зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягтаар хариуцсан нягтлан бодогчид гарган өгч байна" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдлийг ханган, архивын хуульд заасны дагуу баримт бичгийг байгууллагын архивт бүрэн бүрдэлтэй шилжүүлж зөрчлийг арилгах талаар албан шаардлага өгөх.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

"Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхэд болон цэцэрлэгийн багшид зориулсан хоол, шим тэжээлийн мэдлэг олгох" гарын авлага боловсруулах 18,225.0 мянган төгрөгийн гэрээ байгуулсан огноо, ажил гүйцэтгэсэн болон тайлагнасан мөн гэрээ дүгнэсэн цаг хугацаа зөрүүтэй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн ба оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж, анхан шатны баримтыг үнэн зөв, иж бүрэн, бүрдүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох	
					тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар														
1	БШУЯ	АХГ-2022/24/НА-СТА-ТШЗ	Батлагдсан нормоос илүү шатахуун зарцуулдаг том автомашин албан хэрэгцээнд ашиглаж 1,300.0 мянган төгрөгийн шатахуун илүү зарцуулсан.	Төлбөрийн акт	1	1,300.0			1	1,300.0				
2	БШУЯ	АХГ-2022/24/НА-СТА-ТШЗ	Томилолтоор ажиллах удирдамж, томилолтын хуудас, гүйцэтгэсэн ажлын тайлан зэрэг дэмжих баримтгүй 6,809.0 мянган төгрөгийн томилолтын зардлыг олгосон.	Төлбөрийн акт	1	6,809.0			1	6,809.0				
3	БШУЯ	АХГ-2022/24/НА-СТА-ТШЗ	Боловсрол шинжлэх ухааны салбарын хууль тогтоомж, баримт, бичигт зөвлөн туслах гэрээгээр гүйцэтгүүлсэн ажлын тайлан, гэрээ дүгнэсэн актгүйгээр 5,400.0 мянган төгрөгийг олгосон.	Төлбөрийн акт	1	5,400.0			1	5,400.0				
4	БШУЯ	АХГ-2022/24/НА-СТА-ТШЗ	Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулж баяр ёслолын арга хэмжээнд зориулан 2,207.0 мянган төгрөгөөр баглаа цэцэг авч төсвийг үрэлгэн зарцуулсан	Албан шаардлага	1	2,207.0					1	2,207.0		
5	БШУЯ	АХГ-2022/24/НА-СТА-ТШЗ	Бэлэн мөнгөний 11,900.0 мянган төгрөгийн тайлан гаргаагүй, анхан шатны баримтын гарын үсгийн бүрдэл дутуу, баримт үдээгүй	Албан шаардлага	1	11,900.0					1	11,900.0		

Боловсрол шинжлэх ухааны яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

6	БШУЯ	АХГ-2022/24/НА-СТА-ТШЗ	"Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхэд болон цэцэрлэгийн багшид зориулсан хоол, шим тэжээлийн мэдлэг олгох" гарын авлага боловсруулах 18,225.0 мянган төгрөгийн гэрээ байгуулсан огноо, ажил гүйцэтгэсэн болон тайлагнасан мөн дүгнэсэн цаг хугацаа зөрүүтэй.	Зөвлөмж	1	18,225.0									1	18,225.0
7	БШУЯ	АХГ-2022/24/НА-СТА-ТШЗ	Авлага дансанд бүртгэлтэй 28,500.0 мянган төгрөгийг шууд зардалд хааж дансны бичилт буруу хийсэн.	Залруулга хийлгэсэн	1	28,500.0	1	28,500.0								
8	БШУЯ	АХГ-2022/24/НА-СТА-ТШЗ	Урьдчилгаа дансанд бүртгэлтэй 24,450.0 мянган төгрөгийг шууд зардалд хааж дансны бичилт буруу хийсэн.	Залруулга хийлгэсэн	1	24,450.0	1	24,450.0							-	0
9	БШУЯ	АХГ-2022/24/НА-СТА-ТШЗ	Харилцах данснаас 606,832.2 мянган төгрөгийн ажил гүйлгээг тооцоо үүсгээгүй шууд зардлын данс руу хааж бичсэн.	Залруулга хийлгэсэн	1	606,832.2	1	606,832.2								
10	БШУЯ	АХГ-2022/24/НА-СТА-ТШЗ	Хагас жилийн санхүүгийн тайланд НДШ-н 18,300.0 мянган төгрөгийн өр төлбөрийг тусгаагүй.	Залруулга хийлгэсэн	1	18,300.0	1	18,300.0								
11	БШУЯ	АХГ-2022/24/НА-СТА-ТШЗ	Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 24 нэр төрлийн 70,299.4 мянган төгрөгийн бараа материалыг данс бүртгэлд бүртгээгүй.	Залруулга хийлгэсэн	1	70,299.4	1	70,299.4								
12	БШУЯ	АХГ-2022/24/НА-СТА-ТШЗ	"Судар бичгийн хүрээлэн-100" буюу орчин цагийн шинжлэх ухааны байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойн цогц арга хэмжээнд тусгагдсан "Шинжлэх ухаан технологийн салбарын эрх зүйн эмхэтгэл" гэсэн 20,000.0 мянган төгрөгийн 1000 номыг бүртгээгүй.	Залруулга хийлгэсэн	1	20,000.0	1	20,000.0								

**Боловсрол шинжлэх ухааны яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

13	БШУЯ	АХГ-2022/24/НА-СТА-ТШЗ	Бараа материалын дансанд 12,300.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бүртгэсэн.	Залруулга хийлгэсэн	1	12,300.0	1	12,300.0										
14	БШУЯ	АХГ-2022/24/НА-СТА-ТШЗ	Жолоочийн зам явах тооцооны хуудасгүй, 12,897.8 мянган төгрөгийн шатахуун зарцуулалтын тооцоо бодоогүй, тайлан гаргаагүй.	Залруулга хийлгэсэн	1	12,897.8	1	12,897.8										
15	БШУЯ	АХГ-2022/24/НА-СТА-ТШЗ	Бараа материалын тайланг нэр төрөл тус бүрээр нь гаргаагүй 41,355.1 мянган төгрөгийн бараа материалыг хольж бүртгэсэн	Залруулга хийлгэсэн	1	41,355.1	1	41,355.1										
16	БШУЯ	АХГ-2022/24/НА-СТА-ТШЗ	Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 1,012,214.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг холбогдох байгууллагад хүргүүлж шийдвэр гаргуулаагүй.	Залруулга хийлгэсэн	1	1,012,214.9	1	1,012,214.9										
17	БШУЯ	АХГ-2022/24/НА-СТА-ТШЗ	Үндсэн хөрөнгөнд 1,020.0 мянган төгрөгийн бараа материалын шинж чанартай хөрөнгийг бүртгэсэн.	Залруулга хийлгэсэн	1	1,020.0	1	1,020.0										
18	БШУЯ	АХГ-2022/24/НА-СТА-ТШЗ	Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 4 нэр төрлийн 20,959.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд бүртгээгүй.	Залруулга хийлгэсэн	1	20,959.7	1	20,959.7										
19	БШУЯ	АХГ-2022/24/НА-СТА-ТШЗ	Шинжлэх ухаан, технологийн салбар, инновацын үйл ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмж гэж үзэж худалдан авсан 125,400.0 мянган төгрөгийн үнэ бүхий 19 ширхэг I Pad үндсэн хөрөнгөнд бүртгээгүй.	Залруулга хийлгэсэн	1	125,400.0	1	125,400.0										
Нийт дүн					19	2,040,370.1	13	1,994,529.1	3	13,509.0	2	14,107.0	-	-	1	18,225.0		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25 № 20/А0150058
АХГ-2022/24/СТА-ТШЗ
Төлбөр барагдуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Боловсрол, шинжлэх ухааны яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Батлагдсан нормоос илүү шатахуун зарцуулдаг автомашин албан хэрэгцээнд ашиглаж 1,300,000.00 (нэг сая гурван зуун мянга) төгрөгийг зарцуулсан;
- Томилолтын хуудас, гүйцэтгэсэн ажлын тайлан, удирдамж зэрэг анхан шатны баримтгүй 6,809,000.00 (зургаан сая найман зуун есөн мянга) төгрөг олгосон;
- Хувь хүнтэй зөвлөн туслах ажлын гэрээ байгуулан гүйцэтгэсэн ажлын тайлан, гэрээ дүгнэсэн актгүйгээр 5,400,000.00 (таван сая дөрвөн зуун мянга) төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай", Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолоор баталсан "Суудлын авто машины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" 8 дахь заалт "Төсвөөс санхүүждэг байгууллага хот дотор ажил, үйлчилгээнд хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж 2500см³-ээс дээш туулах чадвар өндөртэй, шатахуун их зарцуулдаг автомашин хэрэглэх, бүх шатны байгууллага, албан тушаалтан эрхлэх асуудлын хүрээний болон харьяа байгууллагаас автомашин гаргуулан хэрэглэх, шатахууны зардлыг төлүүлэхийг тус тус хориглосугай" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.2.3 заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төсвийг үр ашиггүй зарцуулсан 13,509,000.00 төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банканд дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх,
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Боловсрол шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, нягтлан бодогч Б.Мэнд-Амар нарт хариуцуулав.

АКТЫГ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Ж.ЭНХТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264200

\\10.10.10.20\Bil\Hg_Khereg\Akt\2022\0225 Auditin 2 Газар-21.Docx

9006109
9019120396

001030079



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 169/10150058

Улаанбаатар хот

АХГ-2022/24/СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Боловсрол, шинжлэх ухааны яамны 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Баяр ёслолын тэвчиж болох арга хэмжээнд 2,207,000.0 төгрөгийг зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын 1.1. "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх..." гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- 1.Төсвийг хэмнэлттэй, зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж дээрх зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, нягтлан бодогч Б.Мэнд-Амар нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Ж.ЭНХТУЯА





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 140/10150058
АХГ-2022/04/СТБ-ТМЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Боловсрол, шинжлэх ухааны яамны 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бэлэн мөнгөний гүйлгээний 11,900,000.0 төгрөгийн тайлан гаргаагүй. Анхан шатны бүрдэл дутуу баримтаар бэлэн мөнгө зарцуулсан. Санхүүгийн баримтын иж бүрдлийг хангасан архивын хадгаламжийн нэгж үүсгээгүй.

Энэ нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Сангийн сайдын 2000 онд баталсан Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 10. "Өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого, зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягтаар хариуцсан нягтлан бодогчид гарган өгч байна" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтын бүрдлийг ханган, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн заасны дагуу дээрх зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, нягтлан бодогч Б.Мэнд-Амар нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
ЖЭНХТУЯА

